



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/371

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аюулгүй байдал, хамгаалалтын албаны нохойн байр хамгаалалтын хашаа барих ИНҮТ/УЗ/ХА/А-124/21 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Д.Ганхуяг

"Аюулгүй байдал, хамгаалалтын албаны Үзлэг шалгалт, хамгаалалтын хэсгийн дарга

Гишүүд

Ж.Ганбаатар

Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Барилга, байгууламжийн засварын хэсгийн инженер

Б.Оюунчимэг

Худалдан авах ажиллагааны тасгийн ахлах инженер

С.Батболд

Аюулгүй байдал, хамгаалалтын албаны Үзлэг шалгалт, хамгаалалтын хэсгийн нохой сургагч мэргэжилтэн

Х.Мянганжадамба

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Гүйцэтгэсэн ажлыг гэрээнд заасан тоо хэмжээ, ажлын даалгавар холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээн авах комисс (Д.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ